ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/83/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Хотын нэр оруулах)
2018 он


| | |
|---|---|
| Тэргүүлэх аудитор: | Ч.Ариунаа |
| Утас: 7052-2734 | Цахим хаягdornogovi@audit6gov.com |
| Аудитын менежер: | Ц.Лүндэгмаа |
| Утас:7052-3020 | Цахим хаяг: .............................. |
| Аудитор: | Б.Байгал |
| Утас: 99359854 | Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ ....... 3
2 Аудитын тайлан ....... 5
2.1 Оршил ....... 5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ....... 5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ....... 6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ....... 6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ....... 7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ....... 8
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ....... 8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ....... 8
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ....... 10
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ....... 10
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ....... 11
2.11 Шилэн дансны мэдээлэл ....... 12
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ....... 12
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ....... 12
3 Менежментийн захидал ....... 13
3.1 (Аудитын чиглэл) .......
3.1.1 Илрүүлэлт: .......
3.1.2 Эрсдэл: .......
3.1.3 Өгсөн зөвлөмж: .......
3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .......
3.2 (Аудитын чиглэл) .......
3.2.1 Илрүүлэлт: .......
3.2.2 Эрсдэл: .......
3.2.3 Өгсөн зөвлөмж: .......
3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .......
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан .......
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .......
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .......
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019-02-19 № 1-6/86

танай ____________-ны № ____________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙХАНДУЛААН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.НЯМЖАВ

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Сайхандулаан сумын ЕБС-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Аудитын гол асуудал:**

- Багш ажилчдад 1,2,4 дүгээр улиралд олгосон 12724,3 мянган төгрөгийг үр дүнгийн урамшуулал цалингийн үнэлгээг сар бүр үнэлээгүй улиралд нэг удаа үнэлсэн, хувь хэмжээг нь илүү болон дутуу олгож үр дүнгийн улирлын шагналт цалинг илүү болон дутуу олгосон байна. Ажлын үр дүнг үнэлж олгож байгаа мөнгөн урамшууллыг ажлыг бодиттой үнэлэхгүйгээр хавтгайруулан олгож байгаа нь уг урамшуулал ажил сайжруулах урамшууллын хэлбэр болж чадахааргүй байна.
- 2018 оны жилийн төсөвт тусгагдсан 17246,0 мянган төгрөгийн хүүхдийн хоолны санхүүжилтийг ТБОНӨХБАУХАТХуулийг зөрчин харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүйгээр иргэнтэй шууд гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон байна. Энэ нь бусдад тэгш байдлыг олгоогүй, үнийн харьцуулалт хийгээгүй төсвийн арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байх эрсдэлтэй байна.

Дээрх зөрчлүүд нь Засгийн газрын 2017 оны 346 дугаар тогтоолын 2.1, "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын дотоод журам ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэсэн, байгууллагын орчин ажлын байранд хөдөлмөрийн сахилга, хариуцлага,ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, албан хаагчдад олгоно." 2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг,ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож улирал бүр олгоно." ТБОНӨХБАУХАТХ-ийн 8.4.-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журам 9.1.2. тухайн жилд төсвийн байгууллагын нийлүүлэгчтэй байгуулсан худалдан авах гэрээ захиалгын үнийн нийт дүн нь жилийн батлагдсан төсвийн хүрээнд байна, 9.1.4. энэхүү журмын 9.2 дахь заалтад хамаарахаас бусад тохиолдолд урсгал санхүүжилтийн данснаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс дээш үнийн дүнтэй худалдан авалтын гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан ТТ-4 маягтын хамт Төрийн санд хүргүүлж батлагдсан төсвөөс нөөц үүсгэн бүртгүүлнэ. заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

# 2 Аудитын тайлан

## 2.1 Оршил

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг  Захирал Нямжав-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.1 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.15-наас 2019.02.17–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.19-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын гэрээт аудитын “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК  хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.02.15-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.2 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь Суралцагчийн онцлог, ялгаатай байдлыг харгалзан хичээл бүрийг чанартай бэлтгэн, суралцагчийг суралцах идэвх оролцоог урамшуулан дэмжих замаар сурлагын чанарт ахиц гаргана. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын нэг буюу хэд хэдэн төвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх,

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- ИТХ-ийн тогтоолууд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

БСШУС сайд Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн тэвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах  гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.5 Төлөвлөлтийн ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аудитын явцад Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 0 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.6 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь сонгосон эрсдэлтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны  мянган төгрөг бөгөөд түүний  хувь болох  мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг  хувиар тооцсон нь холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 0 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг B30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг B501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 1 | 0.00 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 0.00 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 2 | 29970,3 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 2 | 29970,3 | |

## 2.8 ЗӨВЛӨМЖ ӨГӨХӨӨС БУСАД ХЭЛБЭРЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1 Багш ажилчдад 1,2,4 дүгээр улиралд олгосон 12724,3 мянган төгрөгийг үр дүнгийн урамшуулал цалингийн үнэлгээг сар бүр үнэлээгүй улиралд нэг удаа үнэлсэн, хувь хэмжээг нь илүү болон дутуу олгож үр дүнгийн улирлын шагналт цалинг илүү болон дутуу олгосон байна. Ажлын үр дүнг үнэлж олгож байгаа мөнгөн урамшууллыг ажлыг бодиттой үнэлэхгүйгээр хавтгайруулан олгож байгаа нь уг урамшуулал ажил сайжруулах урамшууллын хэлбэр болж чадахааргүй байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 346 дугаар тогтоолын 2.1, “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын дотоод журам ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэсэн, байгууллагын орчин ажлын байранд хөдөлмөрийн сахилга, хариуцлага,ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, албан хаагчдад олгоно.” 2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг,ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож улирал бүр олгоно.” заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Албан шаардлага тогтоож хэрэгжилтийг 2019 оны 06 дугаар сарын 25-нд Дорноговь аймгийн Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т ирүүлэхийг удирдлагад үүрэг болгов.

2.8.2 2018 оны жилийн төсөвт тусгагдсан 17246,0 мянган төгрөгийн хүүхдийн хоолны санхүүжилтийг ТБОНӨХБАҮХАТХуулийг зөрчин харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүйгээр иргэнтэй шууд гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон байна. Энэ нь бусдад тэгш байдлыг олгоогүй, үнийн харьцуулалт хийгээгүй төсвийн арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байх эрсдэлтэй байна.

Дээрх зөрчил нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.4.-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журам 9.1.2. тухайн жилд төсвийн байгууллагын нийлүүлэгчтэй байгуулсан худалдан авах гэрээ захиалгын үнийн нийт дүн нь жилийн батлагдсан төсвийн хүрээнд байна, 9.1.4. энэхүү журмын 9.2 дахь заалтад хамаарахаас бусад тохиолдолд урсгал санхүүжилтийн данснаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс дээш үнийн дүнтэй худалдан авалтын гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан ТТ-4 маягтын хамт Төрийн санд хүргүүлж батлагдсан төсвөөс нөөц үүсгэн бүртгүүлнэ. гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Албан шаардлага тогтоож хэрэгжилтийг 2019 оны 12 дугаар сарын 25-нд Дорноговь аймгийн Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т ирүүлэхийг удирдлагад үүрэг болгов.

## 2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Анхаарал татахуйц бусад асуудал байхгүй байна.

## 2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 10 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 282,803,1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлд, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 282,001,1 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байгаа нь тайлант жилд 802,0 мянган төгрөгийг татан төвлөрүүлснээс шалтгаалжээ.

## 2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## 2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

**Илрүүлэлт**

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд тухайн байгууллагын тайлант онд дэвшүүлсэн зорилго зорилт, болон үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэл авах боломж хангалтгүй байна. Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний үүргийн биелэлтийн тайлан, тухайн байгууллагын үйл ажиллагааны тайлангууд, санхүүгийн тайлан тодруулгад төсөв санхүүгийн үр дүн, гүйцэтгэлийн тоо мэдээлэл, тайлант онд хийгдсэн  их болон урсгал засвар, худалдан авсан тоног төхөөрөмж түүний ашиглалт, ач холбогдлын талаар тусгахгүй байна. УСНББОУС-ийн 1-д заасны дагуу хэрэглэгчдэд ойлгомжтой байлгахын тулд зэрэгцүүлэгдэх мэдээлэлд хүүрнэсэн тайлбар хийгээгүй, худалдан авалт хийхдээ Е баримтыг авч баримтад хавсаргаагүй байна. Энэ нь их бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОС-1-53, “Тайлант үеийн санхүүгийн тайланг ойлгомжтой болгохын тулд зэрэгцүүлэг дэх мэдээлэлд хүүрнэсэн ба тайлбарласан мэдээллийг багтаах хэрэгтэй” Төсвийн тухай хууль 40.2.-т “Энэ хуулийн 40.1-д заасан “үр дүнгийн гэрээнд байгууллагын төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн төсөв, хүрэх үр дүн, түүнийг дүгнэх талаар тусгасан байна.” заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

**Эрсдэл**

1. Тухайн байгууллагын тайлант оны санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлангуудаас хэрэглэгчид шуурхай мэдээлэл авах боломж алдагдана.

**Зөвлөмж**

Санхүүгийн тайлангийн мэдээллийг ямар ч төвшний хэрэглэгч шуурхай авах боломжоор хангаж хүүрнэсэн тайлбар тодруулгыг хийж байх, төсвийн санхүүжилт аар худалдан авалт хийсэн тухай бүр Е баримтыг хавсаргах

**Хариуцах ажилтан**

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн ийн Захирал Б.Нямжав, нягтлан бодогч Э.Алтанчимэг

**Төсвийн захирагчийн хариу**

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 17-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ЛҮНДЭГМАА Огноо:

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР Б.БАЙГАЛ Огноо:

**СТ-1А**

# 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **45,579,617.00** | **38,344,050.00** |
| **33** | **АВЛАГА** | 286,089.00 | 155,807.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 286,089.00 | 154,807.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 1,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 00.00 | 1,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 45,293,528.00 | 38,188,243.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 46,150.00 | 180,450.00 |
| 35130 | Эм боох материал | 46,150.00 | 180,450.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 45,247,378.00 | 38,007,793.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 686,860.00 | 201,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 35,969,628.00 | 30,301,161.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 7,057,000.00 | 6,051,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,433,890.00 | 1,354,132.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 100,000.00 | 100,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **669,331,501.52** | **687,595,140.97** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 669,331,501.52 | 687,595,140.97 |
| **392** | **Биет хөрөнгө** | 669,331,501.52 | 675,283,140.97 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 727,160,561.00 | 598,717,215.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -129,478,034.43 | 8,883,350.36 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 75,882,418.91 | 77,382,418.91 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -21,147,138.33 | -26,657,474.19 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,556,899.36 | 31,900,899.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16,874,654.99 | -18,174,718.47 |
| 39217 | Ном | 3,231,450.00 | 3,231,450.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 00.00 | 12,312,000.00 |
| 39301 | Програм хангамж | 145,000.00 | 145,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -145,000.00 | -145,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 12,312,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **714,911,118.52** | **725,939,190.97** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **846,090.00** | **81,888.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 846,090.00 | 81,888.00 |
| **413** | **Өглөг** | 846,090.00 | 81,888.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | |
| **4136** | **Бусад өглөг** | 11,100.00 | 11,100.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 11,100.00 | 11,100.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **714,065,028.52** | **725,857,302.97** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 714,065,028.52 | 725,857,302.97 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 522,673,143.14 | 534,985,143.14 |
| 51101 | Өмч: - төрийн | 522,673,143.14 | 534,985,143.14 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 68,173,202.26 | 36,589,254.90 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 68,173,202.26 | 100,726,632.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -64,137,377.66 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 123,218,683.12 | 154,282,904.93 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **714,911,118.52** | **725,939,190.97** |

**СТ-2А**

## 4.2 АУДИТ ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **217,975,095.00** | **299,134,100.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,807,551.00** | **1,344,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,389,551.00 | 1,344,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,380,551.00 | 1,344,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,380,551.00 | 1,344,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **49,601,144.00** | **14,987,000.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 166,566,400.00 | 282,803,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 14,987,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 14,987,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **158,920,827.14** | **315,633,391.16** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **158,920,827.14** | **315,633,391.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 149,257,627.14 | 295,098,607.16 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 102,710,460.00 | 195,822,472.00 |
| 210101 | Үндсэн цалин | 102,710,460.00 | 195,822,472.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,476,547.00 | 23,715,708.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,476,547.00 | 9,096,457.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 7,031,842.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 2,867,079.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 1,062,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 3,658,330.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,590,217.00 | 31,250,171.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,029,467.00 | 17,130,171.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,495,750.00 | 13,860,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 65,000.00 | 260,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,522,996.00 | 8,139,714.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 307,500.00 | 1,323,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 445,050.00 | 1,478,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 130,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 435,500.00 | 100,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 30,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,334,946.00 | 5,077,014.20 |
| **2105** | **Нормативт зардал** | 9,308,242.10 | 17,931,955.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 78,000.00 | 81,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,883,948.00 | 16,727,903.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 346,294.10 | 1,122,352.80 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 1,286,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 1,286,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 94,000.00 | 196,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 94,000.00 | 196,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 140,000.00 | 865,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 140,000.00 | 865,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,415,165.04 | 15,890,986.16 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,083,750.00 | 3,019,060.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 6,331,415.04 | 12,871,926.16 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,663,200.00 | 20,534,784.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,663,200.00 | 19,732,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,829,800.00 | 6,860,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 3,466,800.00 | 12,872,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 801,984.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 801,984.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **59,054,267.86** | **-16,499,291.16** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,058,429.88 | 47,638,086.50 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,058,429.88 | 4,139,841.79 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 00.00 | 43,498,244.71 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,058,429.88 | -47,638,086.50 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **57,995,837.98** | **00.00** |

**СТ-2А**

## 4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **166,566,400.00** | **297,790,100.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **166,566,400.00** | **297,790,100.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 166,566,400.00 | 282,803,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 14,987,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 14,987,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **140,438,254.00** | **296,290,100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **140,438,254.00** | **296,290,100.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **130,775,054.00** | **275,754,316.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 102,710,460.00 | 194,482,887.00 |
| 210101 | Үндсэн цалин | 77,201,676.00 | 139,698,587.00 |
| 210102 | Нэмэгдэл | 12,323,707.00 | 25,434,400.00 |
| 210104 | Урамшуулал | 4,773,200.00 | 15,940,900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 8,411,877.00 | 13,409,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,476,547.00 | 25,688,213.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,476,547.00 | 18,428,413.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 1,680,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 1,625,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 359,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 3,594,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,473,667.00 | 30,244,171.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,372,067.00 | 17,130,171.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 12,854,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 101,600.00 | 260,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,065,960.00 | 2,508,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 119,060.00 | 200,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 437,200.00 | 1,258,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 200,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 30,000.00 | 290,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 479,700.00 | 310,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 6,160,220.00 | 17,364,145.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 78,000.00 | 216,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,048,620.00 | 16,648,145.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 33,600.00 | 500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 520,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 520,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 94,000.00 | 196,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 94,000.00 | 196,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 140,000.00 | 1,080,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 140,000.00 | 1,080,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 654,200.00 | 3,670,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,000.00 | 570,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 604,200.00 | 3,100,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,663,200.00** | **20,535,784.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,663,200.00 | 19,733,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,829,800.00 | 6,861,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 3,466,800.00 | 12,872,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 801,984.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 801,984.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **26,128,146.00** | **1,500,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **1,500,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **1,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 1,500,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 1,500,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-1,500,000.00** |

**СТ-4А**

## 4.5 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 522,673,143.14 | 123,353,239.35 | -20,926,914.87 | 625,099,467.62 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 134,556.23 | 134,556.23 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **522,673,143.14** | **123,353,239.35** | **-20,792,358.64** | **625,234,023.85** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | -134,556.23 | 00.00 | -134,556.23 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 32,657,199.00 | 00.00 | 57,995,837.98 | 90,653,036.98 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **522,673,143.14** | **123,218,683.12** | **68,173,202.26** | **714,065,028.52** |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **522,673,143.14** | **123,218,683.12** | **68,173,202.26** | **714,065,028.52** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 32,553,430.30 | 32,553,430.30 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **522,673,143.14** | **123,218,683.12** | **100,726,632.56** | **746,618,458.82** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 31,064,221.81 | 00.00 | 31,064,221.81 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 12,312,000.00 | 00.00 | -64,137,377.66 | -51,825,377.66 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **534,985,143.14** | **154,282,904.93** | **36,589,254.90** | **725,857,302.97** |

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 282,803,200.00 | 282,001,116.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 282,803,200.00 | 282,001,116.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 262,871,200.00 | 262,267,316.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 182,803,700.00 | 182,803,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 128,019,400.00 | 128,019,400.00 |
| 210102 | Нэмэгдэл | 25,434,400.00 | 25,434,400.00 |
| 210104 | Урамшуулал | 15,940,900.00 | 15,940,900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,409,000.00 | 13,409,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,180,500.00 | 23,180,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,992,000.00 | 15,920,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,609,000.00 | 1,680,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,625,800.00 | 1,625,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 359,500.00 | 359,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,594,200.00 | 3,594,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,245,000.00 | 30,244,171.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,130,000.00 | 17,130,171.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,855,000.00 | 12,854,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 260,000.00 | 260,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,510,000.00 | 2,508,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 200,000.00 | 200,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,260,000.00 | 1,258,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 200,000.00 | 200,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 290,000.00 | 290,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 310,000.00 | 310,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 17,962,000.00 | 17,364,145.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 216,000.00 | 216,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,246,000.00 | 16,648,145.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.00 | 500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,020,000.00 | 2,020,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 520,000.00 | 520,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 200,000.00 | 196,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 200,000.00 | 196,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,080,000.00 | 1,080,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,080,000.00 | 1,080,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2870000.00 | 2870000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 570,000.00 | 570,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,300,000.00 | 2,300,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 19932000.00 | 19733800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,932,000.00 | 19,733,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,059,600.00 | 6,861,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,872,400.00 | 12,872,400.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 282,803,200.00 | 282,803,100.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 282,803,200.00 | 282,803,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 282,803,200.00 | 282,803,100.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 1,020.00 | 58,301.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 555.00 | 7,878.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 455.00 | 4,545.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 45,878.00 |